



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар Б/12

Дадал сум

Б.Амаржаргалд түр чөлөө олгох тухай

Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.7, Сургуулийн өмнөх болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4, 60.1.12, Боловсролын Сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаал, тус тушаалын 1 дүгээр хавсралт, Засгийн Газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт, 2018 оны 12 сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1,6-р хавсралт, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэгийн Бэлтгэл Б бүлгийн багшийн туслах (Б.Амаржаргал) нь Солонгос улсад суралцаж амьдардаг том охин руугаа очиж ирэх урилга хүлээн авч чөлөө хүссэн тул 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд ажлын 12 өдрийн цалингүй чөлөө олгосугай.

2. (Б.Амаржаргал)-ыг эргэн ажилдаа орох хүртэл Бэлтгэл Б бүлгийн багшийн туслахаар (Даваамягмарын Энх-Ундрал)-ыг тус бүлэгт түр энэ хугацаанд ажиллуулсугай.

3. Багшийн туслах (Д.Энх-Ундрал)-д хөдөлмөрийн хөлс, үндсэн цалингийн ТҮБД-1 зэрэглэл 1,924,500 /нэг сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуу/ төгрөгөөр бусад нэмэгдлүүдийн хамт үндсэн цалин дээр нэмэн тооцож олгохыг нягтлан бодогч (Ж.Мөнхзул)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ  Н.ОДГАРАВ

